

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Татварын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/129/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум 2025 он	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Ахлах аудитор: Т.Болор Утас: 7036-2442 Цахим хаяг: bolort@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-13
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	14-18
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
4. Аудитын тайлан	19-18
4.1 Ерөнхий зүйл	19
4.2 Материаллаг байдал	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	21
5. Аудитын илрүүлэлт	22
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	23-24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТЕГ	Татварын ерөнхий газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ТАТВАРЫН ГАЗРЫН ДАРГА
Ц.ЛХАГВАДОРЖ ТАНАА

2025.02.25 № СЭА-2025/129/НА-СТА-ТМЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Татварын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид олгодог нэг удаагийн тэтгэмж /6 сарын үндсэн цалинтай тэнцэх/-ийг тус газрын урсгал шилжүүлгийн зардалд баталснаар 13 албан хаагчид нийт 91,554.7 мянган төгрөгийг тооцож, олгосон байна.

Аудитын гол асуудал

Сангийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 33 дугаар тушаалаар баталсан “Татварын улсын байцаагчид ажлын үр дүнгийн шагнал олгох журам”-ын дагуу татварын улсын байцаагчийн ажлын үр дүн, гүйцэтгэлийн

432502058

үнэлгээг үндэслэн сар бүр үндсэн цалингийн 50 хүртэл хувиар тооцон, тайлант онд 232,304.5 мянган төгрөгийн урамшуулал олгосноос гадна улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалд мөн 50 хүртэл хувиар тооцож 80,852.7 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Сэлэнгэ аймгийн Татварын газар нь тайлант онд 4 зорилт, 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 88.5 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	47,207,735.20	65,612,445.20
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	12,500,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	12,500,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	47,207,735.20	53,112,445.20
354	Хангамжийн материал	47,207,735.20	53,112,445.20
35410	Бичиг хэргийн материал	1,613,659.57	3,502,614.19
35420	Аж ахуйн материал	29,140,954.18	31,441,986.37
35440	Түлш, шатах тослох материал	242,690.00	473,440.00
35470	Бусад хангамжийн материал	16,210,431.45	17,694,404.64
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,477,619,657.04	1,438,187,766.95
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,477,619,657.04	1,438,187,766.95
391	Газар	13,890,000.00	13,890,000.00
392	Биет хөрөнгө	1,463,729,657.04	1,424,297,766.95
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,377,165,454.17	1,377,165,454.17
39202	Хуримтлагдсан элэгдэл	(51,630,980.95)	(76,682,121.79)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	113,300,000.00	113,300,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(66,780,844.32)	(85,698,637.68)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	298,142,094.74	347,909,228.49
39206	Хуримтлагдсан элэгдэл	(217,045,617.38)	(264,700,325.84)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	28,693,840.10	32,852,940.10
39208	Хуримтлагдсан элэгдэл	(18,114,289.32)	(19,848,770.50)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,524,827,392.24	1,503,800,212.15
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,524,827,392.24	1,503,800,212.15
51	Засгийн газрын хувь оролцоо	1,524,827,392.24	1,503,800,212.15
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	369,861,425.84	369,861,425.84
51101	Өмч: - төрийн	369,861,425.84	369,861,425.84
512	Хуримтлагдсан үр дүн	1,154,965,966.40	1,133,938,786.31
51210	Өмнөх үеийн үр дүн	(192,490,398.34)	1,154,965,966.40
51220	Тайлант үеийн үр дүн	1,347,456,364.74	(21,027,180.09)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,524,827,392.24	1,503,800,212.15

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,178,160,911.20	2,574,729,196.05
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,335,452,511.20	48,388,933.75
120	Нийтлэг татварын бус орлого	1,335,417,511.20	48,388,933.75
120009	Бусад орлого		
120017	Үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө	1,333,720,418.00	48,167,233.75
120018	Үнэ төлбөргүй бараа материал	1,697,093.20	221,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,842,708,400.00	2,526,340,262.30
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,832,708,400.00	2,307,275,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,832,708,400.00	2,307,275,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,000,000.00	219,064,762.30
131103-350013	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00	213,599,762.30
131104-350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		5,430,000.00
131105-350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	35,000.00	35,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,926,878,433.53	2,595,748,808.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,926,878,433.53	2,595,748,808.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,614,993,257.17	2,429,969,969.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,199,553,192.20	1,864,805,339.44
210101	Үндсэн цалин	677,550,635.40	932,492,317.09
210102	Нэмэгдэл цалин	228,762,240.05	576,740,272.83
210103	Унаа хоолны хөнгөлөлт	68,873,006.90	77,037,800.00
210104	Урамшуулал	224,367,309.85	278,534,949.52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	152,912,553.00	235,683,065.90
210201	Тэтгэврийн даатгал	104,978,173.60	161,471,212.78
210202	Тэтгэмжийн даатгал	12,368,814.69	19,163,941.07
210203	ҮОМШ өвчний даатгал	9,635,451.77	9,308,071.40
210204	Ажилгүйдлын даатгал	2,357,282.99	9,147,968.17
210205	Эрүүл мэндийн даатгал	23,572,829.95	36,591,872.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,900,058.39	35,012,210.50
210301	Гэрэл цахилгаан	5,520,454.43	5,110,106.50
210302	Түлш, халаалт	18,792,265.96	26,960,858.00
210303	Цэвэр, бохир ус	2,587,338.00	2,941,246.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,969,801.63	26,311,932.24
210401	Бичиг хэрэг	6,014,700.00	3,715,157.14
210402	Тээвэр шатахуун	6,260,140.00	12,635,250.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	4,695,698.05	4,527,220.87
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	160,000.00	260,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,839,263.58	5,174,304.23
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,922,699.00	7,899,177.36
210604	Урсгал засвар	2,922,699.00	7,899,177.36
2107	Томилолт, зочны зардал	10,311,000.00	39,310,200.00
210702	Дотоод албан томилолт	10,311,000.00	39,310,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	92,291,132.00	105,159,920.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	91,724,000.00	104,592,030.00
210803	Даатгалын үйлчилгээ	420,180.00	420,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	112,400.00	112,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	12,552.00	13,290.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	104,132,820.95	115,788,123.84
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,050,000.00	17,430,000.00
210902	Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх	6,975,220.00	5,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	87,107,600.95	93,358,123.84
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	311,885,176.36	165,778,838.86
2132	Бусад урсгал шилжүүлэг	56,397,736.00	105,687,425.15
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	47,551,000.00	-
213208	ХОН-т тогтвор суурьшилтэй ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	101,727,425.15
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,846,736.00	3,960,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	255,487,440.36	58,703,603.82
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	255,487,440.36	58,703,603.82
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,387,809.89
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,387,809.89
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,251,282,477.67	(21,019,612.09)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	10,560.00	7,568.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	10,560.00	7,568.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(10,560.00)	(7,568.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,251,271,917.67	(21,027,180.09)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,842,743,400.00	2,538,840,262.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,035,000.00	12,500,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	10,035,000.00	12,500,000.00
120009	Үнэ төлбөргүйгээр хүлээн авсан орлого	10,035,000.00	12,500,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,832,708,400.00	2,526,340,262.30
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,832,708,400.00	2,307,275,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,832,708,400.00	2,307,275,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	219,064,762.30
131103-350013	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		213,599,762.30
131104-350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,430,000.00
131105-350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		35,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,842,743,400.00	2,526,340,262.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,842,743,400.00	2,526,340,262.30
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,530,858,223.64	2,360,561,423.44
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,199,553,192.20	1,877,305,339.44
210101	Үндсэн цалин	677,550,635.40	932,492,317.09
210102	Нэмэгдэл	228,762,240.05	589,240,272.83
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	68,873,006.90	77,037,800.00
210104	Урамшуулал	224,367,309.85	278,534,949.52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	152,912,553.00	235,683,065.90
210201	Тэтгэврийн даатгал	104,978,173.60	161,471,212.78
210202	Тэтгэмжийн даатгал	12,368,814.69	19,163,941.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,635,451.77	9,308,071.40
210204	Ажилгүйдлийн даатгал	2,357,282.99	9,147,968.17
210205	Эрүүл мэндийн даатгал	23,572,829.95	36,591,872.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,900,058.39	35,012,210.50
210301	Гэрэл, цахилгаан	5,520,454.43	5,110,106.50
210302	Түлш, халаалт	18,792,265.96	26,960,858.00
210303	Цэвэр, бохир ус	2,587,338.00	2,941,246.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,032,968.05	29,955,827.60
210401	Бичиг хэрэг	4,675,400.00	4,935,000.00
210402	Тээвэр, шатахуун	6,000,000.00	12,866,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,695,698.05	4,919,777.60
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	160,000.00	260,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,501,870.00	6,975,050.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,398,100.00	14,208,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,900,000.00	1,599,900.00
210602	Тавилга	-	4,159,100.00
210604	Урсгал засвар	2,498,100.00	8,449,800.00
2107	Томилолт, зочны зардал	10,311,000.00	39,310,200.00
210702	Дотоод албан томилолт	10,311,000.00	39,310,200.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	97,725,132.00	106,655,980.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	97,158,000.00	106,088,090.00
210803	Даатгалын үйлчилгээ	420,180.00	420,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	112,400.00	112,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	12,552.00	13,290.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,025,220.00	22,430,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,050,000.00	17,430,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,975,220.00	5,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	311,885,176.36	165,778,838.86
2132	Бусад урсгал шилжүүлэг	56,397,736.00	105,687,425.15
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	47,551,000.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтэй ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	101,727,425.15
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,846,736.00	3,960,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	255,487,440.36	60,091,413.71
2131122	Төсвийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал		58,703,603.82
213303	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал\	255,487,440.36	1,387,809.89
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	12,500,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	12,500,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	12,500,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	369,861,425.84	-	(96,305,951.27)	-	273,555,474.57
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	369,861,425.84	-	(96,305,951.27)	-	273,555,474.57
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
7	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
8	Тайлант үеийн үр дүн	-	-	1,251,271,917.67	-	1,251,271,917.67
9	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	369,861,425.84	-	1,154,965,966.40	-	1,524,827,392.24
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	369,861,425.84	-	1,154,965,966.40	-	1,524,827,392.24
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
13	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
14	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
15	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
16	Тайлант үеийн үр дүн	-	-	(21,027,180.09)	-	(21,027,180.09)
17	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	369,861,425.84	-	1,133,938,786.31	-	1,503,800,212.15

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,348,118,300.00	2,248,571,896.18	99,546,403.82	95.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,348,118,300.00	2,248,571,896.18	99,546,403.82	95.76
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,201,588,000.00	2,142,884,471.03	58,703,528.97	97.33
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,740,211,300.00	1,699,171,958.49	41,039,341.51	97.64
210101	Үндсэн цалин	791,887,500.00	932,492,317.09	(140,604,817.09)	117.76
210102	Нэмэгдэл цалин	430,706,000.00	411,106,891.88	19,599,108.12	95.45
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	92,142,000.00	77,037,800.00	15,104,200.00	83.61
210104	Урамшуулал	425,475,800.00	278,534,949.52	146,940,850.48	65.46
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	214,881,100.00	213,604,494.44	1,276,605.56	99.41
210201	Тэтгэврийн даатгал	146,119,200.00	146,498,175.66	(378,975.66)	100.26
210202	Тэтгэмжийн даатгал	17,190,500.00	17,402,408.22	(211,908.22)	101.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,595,200.00	8,417,404.52	177,795.48	97.93
210204	Ажилгүйдлийн даатгал	8,595,200.00	8,257,301.29	337,898.71	96.07
210205	Эрүүл мэндийн даатгал	34,381,000.00	33,029,204.75	1,351,795.25	96.07
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,136,500.00	35,012,210.50	16,124,289.50	68.47
210301	Гэрэл, цахилгаан	6,240,000.00	5,110,106.50	1,129,893.50	81.89
210302	Түлш, халаалт	40,896,500.00	26,960,858.00	13,935,642.00	65.92
210303	Цэвэр, бохир ус	4,000,000.00	2,941,246.00	1,058,754.00	73.53
2104	Хангамж, бараа материалын зардал	30,126,000.00	29,920,827.60	205,172.40	99.32
210401	Бичиг хэрэг	4,900,000.00	4,900,000.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	12,866,000.00	12,866,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,600,000.00	4,919,777.60	680,222.40	87.85
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360,000.00	260,000.00	100,000.00	72.22
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,400,000.00	6,975,050.00	(575,050.00)	108.99
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,209,100.00	14,208,800.00	300.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,600,000.00	1,599,900.00	100.00	99.99
210602	Тавилга	4,159,100.00	4,159,100.00	-	100.00
210604	Урсгал засвар	8,450,000.00	8,449,800.00	200.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	39,328,000.00	39,310,200.00	17,800.00	99.95
210702	Дотоод албан томилолт	39,328,000.00	39,310,200.00	17,800.00	99.95
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	106,696,000.00	106,655,980.00	40,020.00	99.96
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	106,128,000.00	106,088,090.00	39,910.00	99.96
210803	Даатгалын үйлчилгээ	420,200.00	420,200.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	112,400.00	112,400.00	-	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00	-	100.00
210807	Газрын төлбөр	13,400.00	13,290.00	110.00	99.18

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	146,530,300.00	105,687,425.15	40,842,874.85	72.13
2132	Бусад урсгал шилжүүлэг	146,530,300.00	105,687,425.15	40,842,874.85	72.13
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	40,842,800.00	-	40,842,800.00	-
213208	ХОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	101,727,500.00	101,727,425.15	74.85	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,960,000.00	3,960,000.00	-	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,348,118,300.00	2,348,118,300.00	-	100.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,348,118,300.00	2,348,118,300.00	-	100.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	2,348,118,300.00	2,348,118,300.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		217,676,952.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ		217,676,952.41
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		217,676,952.41
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил		178,133,380.95
210102	Нэмэгдэл цалин		178,133,380.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		22,078,571.46
210201	Тэтгэврийн даатгал		14,973,037.12
210202	Тэтгэмжийн даатгал		1,761,532.85
210203	ҮОМШӨ-ний даатгал		890,666.88
210204	Ажилгүйдлийн даатгал		890,666.88
210205	Эрүүл мэндийн даатгал		3,562,667.73
2104	Хангамж, бараа материалын зардал		35,000.00
210401	Бичиг хэрэг		35,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		17,430,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		17,430,000.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		219,064,762.30
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		219,064,762.30
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		213,599,762.30
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		5,430,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		35,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Татварын газар *Ицаашид Татварын газар гэх* нь “Татварын хууль тогтоомж даган мөрдөлтийн эрсдэлийг удирдах, хууль тогтоомжийг сайн дураар даган мөрдөлтийг олон улсын түвшинд хүргэх, улс, орон нутгийн төсвийн татварын орлого бүрдүүлэх” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулжээ.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт сурталчилгаа явуулах,
- Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих,
- Улс, орон нутгийн төсвийн татварын орлого бүрдүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,
- ТЕГ-ын даргын 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/03 дугаар тушаалаар аймгийн татварын хэлтсийг аймгийн татварын газар гэж өөрчилсөн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Татварын газрын санхүүгийн үйл ажиллагаанд ТЕГ-ын “Дотоод аудит, хяналт, шинжилгээ, үнэлгээний газар”-аас хяналт тавьж ажилладаг бөгөөд тайлант онд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Татварын газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ТЕГ-ын даргын 2020 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/156 дугаар тушаалаар баталсан “Монголын татварын албаны нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Татварын газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 21,027.2 мянган төгрөгөөр буюу 1.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	12,500.00	12,500.00
Авлага	-	-	-
Бараа материал	47,207.74	53,112.45	5,904.71
Үндсэн хөрөнгө	1,477,619.66	1,438,187.77	(39,431.89)
Нийт хөрөнгө	1,524,827.39	1,503,800.21	(21,027.18)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,524,827.39	1,503,800.21	(21,027.18)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,524,827.39	1,503,800.21	(21,027.18)

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн данс 12,500.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь тус газрын даргын 2024 оны А/56 дугаар тушаалаар “Ахмадын сангийн ажиллах журам”-ыг боловсруулж, цалингийн сангаас 12,500.0 мянган төгрөгийг төрийн сан дахь Ахмадын сангийн 100130011501 тоот дансанд төвлөрүүлж, үлдэгдлээр тайлагнаснаас,
- Бараа материалын дансны үлдэгдэл 53,112.5 мянган төгрөг болж 5,904.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 45,609.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 39,705.2 мянган төгрөгийн материал зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,438,187.7 мянган төгрөг болж, 39,431.9 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 5,759.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, ТЕГ-аас 48,167.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж шилжүүлэн авсан болон 93,358.1 мянган төгрөгийн элэгдлийн зардал нэмж байгуулснаас
- Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ данс 21,027.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс тус тус шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг /улсын төсвөөс/ 1,895,529.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос олгох НДШ-ийн зардлыг 156,496.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 850.2 мянган төгрөгөөр зэрэг нийт 157,346.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 4,161.4 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 6,351.0 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 118,028.2 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 2,432.0 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийг 101,427.7 мянган төгрөгөөр зэрэг нийт 232,400.4 мянган төгрөгөөр бууруулж, 1,820,475.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн зохицуулалт, тодотголоор цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос олгох НДШ-ийн зардлыг 295,752.7 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 21,096.5 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 15,766.0 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 11,209.1 мянган төгрөг, томилолт, зочны зардлыг 36,928.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 3,000.0 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийг 143,890.3 мянган төгрөг зэргээр батлагдсан төсвийг нийт 527,642.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, **2,348,118.3** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,348,118.3 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөн, гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,348,118.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,248,571.9 мянган төгрөг буюу 95.8 хувьтай тайлагнагдсан байна.

Үндсэн үйл ажиллагааны зардал 58,663.6 мянган төгрөг, мэдээлэл, сурталчилгааны зардал 3.9 мянган төгрөг, холбооны суваг ашигласны хөлс 36.0 мянган төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг 40,842.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

			/мянган төгрөгөөр/			
д/д		Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	70701	Татвар хураалт, орлого бүрдүүлэлт				
1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	2,095,460.0	2,036,796.4	58,663.6	97.2
2	80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	1,500.0	1,496.1	3.9	99.7
3	80219	Харуул, хамгаалалтын зардал	43,200.0	43,200.0	-	100.0
4	80220	Холбооны суваг ашигласны хөлс	61,428.0	61,392.0	36.0	99.9
5	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	146,530.3	105,687.4	40,842.9	72.1
		Дүн	2,348,118.3	2,248,571.9	99,546.4	95.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130011401 тоот дансанд аймгийн санхүүгийн дэмжлэгээс орон нутгийн нэмэгдэл цалинд 201,109.7 мянган төгрөг, Ерөө сумаас орон нутгийн нэмэгдэл цалинд 490.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын 2024 оны А/18, А/194, А/415 дугаар захирамжуудаар Татварын албаны төвийн бүсийн сургалтын зардалд 10,000.0 мянган төгрөг, татвар төлөгчдийн өдөрт 5,430.0 мянган төгрөг, тэргүүний байгууллагын шагналд 2,000.0 мянган төгрөг зэрэг нийт 219,064.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардалд 178,133.4 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардалд 22,078.5 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 35.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 17,430.0 мянган төгрөг, нийт 217,676.9 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 1,387.8 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, байгууллагын даргаар батлуулсны дагуу тухай бүр гэрээ байгуулж, худалдан авалтыг хийж, гүйцэтгэсэн байна.

Тайлант онд шууд худалдан авах босго үнээс давсан 43,200.0 мянган төгрөгийн харуул хамгаалалтын үйлчилгээний худалдан авах ажиллагааг цахимаар зарлаж, сонгон шалгаруулалтын үр дүнг үндэслэн Шүрэн-Үндэс ХХК-тай гэрээ байгуулж, гүйцэтгүүлсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Татварын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Болор гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Татварын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 68 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,926,878.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 19,268.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор тус байгууллага нь шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй, байгууллагын гэрэл, цахилгааны хэрэглээг хэмнэсэн зэргээр төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, баталсан төсвийн хүрээнд ил тод байдлыг ханган ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Татварын газрын мэдээлбэл зохих 29 төрлийн 183 мэдээллээс 28 төрлийн 182 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, “Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан” мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалтуудыг тус тус зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж байх зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 173 дугаар “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төлөвлөлтийг бодит хэрэгцээ шаардлага, судалгаанд үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс ZOOM APP-ийн 12 сарын эрх авахад 840.0 мянган төгрөгийг шуудан холбоо, интернэтийн төлбөрийн зардлаас санхүүжүүлсэн зөрчилд зөвлөмж өгөгдсөнийг биелүүлж ажилласан байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	1	840.0	1	840.0	100
Нийт дүн	1	840.0	1	840.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн **12,500.0** мянган төгрөгийн зөрчилд **1** зөвлөмж хүргүүлээ.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь “... байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах ...”, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын 1.3 дахь “Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн 3 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана” гэсэн заалтыг хэрэгжүүлж, зайлшгүй гарах зардлыг төсвийн төлөвлөгөөнд тусган батлуулаагүйгээс цалин хөлс, урамшууллын батлагдсан төсвөөс **12,500.0** мянган төгрөгийг төрийн сан дахь Ахмадын сангийн 100130011501 дугаар дансанд шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 5.1.2: Төсвийн иж бүрэн, **үнэн зөв байдлыг хангасан байх**” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь заалтыг хэрэгжүүлэн тухайн жилийн төсвийн төлөвлөгөөнд “Ахмадын сан”-ийн зардлыг тусган, батлуулах.

Дээрх **зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг** Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5¹-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй			
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн				Тоо	Дүн		Тоо	Дүн
Ахмадын сангийн эх үсвэрийг төсөвт тусган батлуулалгүйгээр цалин, урамшууллын төсвөөс шилжүүлсэн	1	12,500.0			1	12,500.0				
Дүн	1	12,500.0			1	12,500.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан.	1	-			1	-
Дүн	1	-			1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Дүн						
Нийт дүн	1				1	